

**“ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2015 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл		
1.	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн тайлан, УИХ-ын тогтоол, 1998, №29	Хөтөлбөрийн зорилго: Монгол орны экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газар нутгийг хамарсан тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал болон олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтооход оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв нийт 6,7 тэрбум төгрөг: 2015 онд зөвхөн НҮБХХ-ийн “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн 500 сая төгрөг		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОНХАЖЯ-ны ТХНУГ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: - Орон нутгийн захиргааны байгууллага - ТХГН-ийн Хамгаалалтын захиргаад		
4.	Хөтөлбөрийн зорилтууд	<u>Зорилт 1:</u> Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, онцгой ач холбогдол бүхий газар нутаг ТХГН-ийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ. <u>Зорилт 2:</u> Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгож сүлжээг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний орчны бүсэд амьдарч буй хүмүүсийг тухайн нутгийн төлөвлөлт, хамгаалалтын үйл ажиллагаанд өргөнөөр харуулан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.		
5.	Зардал	Төсөв 2015 500 сая	Гүйцэтгэл 500 сая	Хувь 100%
		НҮБХХ-ийн буцалтгүй тусламжийн төслөөс		
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ		
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	2015 оны байдлаар ТХГН-ийн сүлжээг үе шаттайгаар өргөжүүлж ирснээр нийт 27,2 сая га талбай бүхий 99-н байршилд 87 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулаад байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 17,4 хувийг эзэлж байна. Мөн сум, аймгийн ИТХ-ийн шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 16.31 сая га талбай бүхий 911 газар хамрагдаад байгаа нь Монгол Улсын нийт газар нутгийн 10.3 хувийг эзэлж байна.		
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн2: Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	1.“Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” 1994 он, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль” 1998 онд батлагдсаныг хөгжлийн өнөөгийн хандлага, нийгэм эдийн засгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэн найруулж, хуулийн төслийг холбогдох талуудын оролцоотой боловсруулан, БОНХАЖ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлснээр ЗГ-ын 2015 оны 12 сарын 21-ны өдрийн хуралдаанаар дэмжигдэж, УИХ-д өргөн барихаар		

		<p>төлөвлөн ажиллаж байна. 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/7423 тоот албан бичгээр Хууль зүйн сайд, Сангийн сайдтай хамтран баталсан хуулийн төслийн үзэл баримтлал, шинэчилсэн найрууллагын төсөл болон холбогдох материалуудыг хүргүүлсэн болно.</p> <p>2.“Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дуусч байгаатай холбогдуулан, үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шинэчилсэн төслийг боловсруулан, хөтөлбөрийн үзэл баримтлалыг 2015.10.28-ны өдөр Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Хууль зүйн яаманд хүргүүлэн батлуулсан. Хөтөлбөрийн хавсралтаар 2016-2030 он хүртэлх хугацаанд Улсын тусгай хамгаалалтад хамруулах газар нутгуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрэмбэлэн, жагсаалтыг аймаг, сумдаар гаргаж, ЗГХЭГ-т хүргүүлэв.</p> <p>3. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний 4 чуулганыг “Тусгай хамгаалалттай газар нутаг-Олон Улсын болон Монгол Улсын төрийн бодлого” сэдвийн хүрээнд 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “Чингис зочид” буудалд зохион байгуулав. Чуулганыг зохион байгуулсан үндсэн зорилго нь ТХГН-ийн талаарх төрийн бодлого, хөтөлбөр, олон улсын конвенцийг хэрэгжүүлэхэд салбарын оруулж буй хувь нэмрийг үнэлэх, ТХГ-ын хамгаалалтын менежментийг сайжруулахад олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтыг тодорхойлов. Чуулганаас гаргасан зөвлөмжийг УИХ, ЗГ, Аймаг ИТХД, Засаг дарга, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад, гадаадын төлөөлөгчид, хамтран ажиллаж буй олон улсын байгууллагын төлөөлөлд албан тоотоор хүргүүлсэн ба мэдээллийг олон нийтэд өдөр тутмын сонин, сайтуудаар нийтлүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулав.</p> <p>4. ТХГН-ийн сүлжээний хэмжээнд боловсон хүчнээр хангах асуудал шийдвэрлэгдэж, тус сүлжээнд 607 хүн ажиллаж байна. Байгаль хамгаалагчид Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцуулах бодлогын баримт бичиг болон шалгуур үзүүлэлтийг боловсруулан талуудын хэлэлцүүлгийг БОНХАЖЯ-нд 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, саналыг тусган эцэслэн, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцуулах хэлбэрийг тодорхойлох журмын төслийг бэлтгэж байна.</p> <p>5. Сургалт, сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд /төв болон орон нутгийн хэмжээнд/ зохион байгуулж, “ТХГН-ийн үүрэг, ач холбогдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, хүн амын мэдлэг, мэдээллийн түвшинг байнга дээшлүүлнэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор олон талт ажлуудыг хэрэгжүүлснээр иргэд болон орон нутгийн захиргаадын байгаль хамгаалах ухамсар, ойлголт, тэдний хамтран ажиллах сонирхол, хандлага ихээхэн нэмэгдсэн.</p>
	<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 3:</p>	<p>1.“Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачилсан зөвлөмж”-ийн дагуу 30 орчны</p>

		<p>бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан холбогдох сумдын Засаг дарга нар батлан хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг улсын хэмжээнд шинэчлэн нэгдсэн мэдээллийг гаргав.</p> <p>3. “Эко бүс нутаг” хөтөлбөрийг БОНХАЖ-ын сайдын зөвлөлийн хурлаар 2015 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр хэлэлцүүлэн дэмжүүлэв.</p> <p>4. Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадын /33/ менежментийн төлөвлөгөөг шинэчилсэн зааврын дагуу /МИРАДИ программ/ шинэчлэн боловсруулж, батлуулав.</p> <p>5. Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах аялал жуулчлалын ажлын үр дүнг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор аялалын маршрутуудыг албан ёсоор тогтоох ажлыг зохион байгуулж, Богдхан, Хан Хэнтий, Орхоны хөндийн БЦГ-т үндсэн 4 маршрут, дэд 15 маршрут, Горхи-Тэрэлжийн БЦГ-т үндсэн 5 маршрут, төрөлжсөн 9 маршрутийг тогтоов.</p>
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Хөтөлбөрийн 2 дахь үе шатны хэрэгжилтийн хугацаа дуусч байгааг дүгнэхэд, дараах <u>ололт, үр дүн гарав</u>. Үүнд:</p> <p>1. Тогтвортой хөгжлийн талаарх төрийн бодлогын зорилтууд хэрэгжиж, үр дүнгээ өгч эхэлсэн.</p> <p>2. “Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн Монгол улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг 2015 онд 30 хувьд, үүнээс 15 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах” зорилт тавьж ажилласнаас 2015 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 17.4 хувийг буюу 27.2 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад, нийт нутаг дэвсгэрийн 10.3 хувийг буюу 16.3 сая гаруй га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад хамруулснаар, улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нийт талбай 43.5 сая га-д хүрч, нийт нутаг дэвсгэрийн 27.7 хувийг эзэлж байна. Түүнчлэн БОНХАЖЯ-аас 2.1 сая гаруй га талбай бүхий нийт нутаг дэвсгэрийн 1.8 хувьтай тэнцэх газар нутгийг өргөтгөл болон нэмэлт байдлаар улсын тусгай хамгаалалтад авах бэлтгэл ажлыг хангасан болно.</p> <p><u>3. Хамарсан экосистем:</u></p> <p>1. 12.4 сая га-20 ДЦГ, 11.7 сая га-32 БЦГ нь байгалийн үндсэн бүс, бүслүүрийн унаган төрхийг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад голлох үүрэг гүйцэтгэж байна.</p> <p>2. Монгол орны өндөр уулын 11,1-40,7%, ойн 9,9-31,1%, хээрийн 4,2-7,6%, ус, намгархаг газрын 13,9-79,0%, говь цөлийн 13,9-74,1%, өвөрмөц экосистемийн 9-79,3% нь ТХГН-ийн сүлжээнд хамрагдсан байна.</p> <p>3. Ойн сангийн талбайн 70 орчим хувь, томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эх болон гадаргын усны эзлэх нутаг дэвсгэрийн 10 орчим хувь, устах аюулд орсон болон устаж болзошгүй 300 гаруй амьтан, ургамлын үндсэн тархац нутгийн 60 гаруй хувь, байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын үнэт өв бүхий газар нутгийн 80 гаруй хувийг улсын тусгай хамгаалалтад</p>

		<p>хамруулсан байна.</p> <p><u>4.Экосистемийн үйлчилгээ, аялал жуулчлал:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын баазын 80 орчим хувь хамрагдаж байна. 2. Жилд 250 мянга орчим гадаад, дотоодын жуулчид, аялагчдыг хүлээн авч, ажлын байр бий болгож, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж байна. <p><u>5.Олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээрт хамрагдсан байдал:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Дэлхийн байгаль, соёлын өвийн жагсаалтад-4, Дэлхийн соёлын өвийн жагсаалтад-2, Олон улсын хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээнд-7, Рамсарын конвенцийн хавсралтад-11 нуур, түүний орчмын бүс, ус, намгархаг газар тусгай хамгаалалттай газар тус тус хамрагдсан. 2. Дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн мэдээлэлд Монгол орны 99 тусгай хамгаалалттай газар нутаг бүртгэгдэв. 3. Монгол улс тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой олон улсын хэмжээний 6 конвенцид нэгдэн орсон. 4. Монгол улсын санаачлагаар хөрш улсуудтай хил дамнасан болон зэрэгцсэн хамгаалалттай газар нутаг бий болгох ажлыг эхлүүлж, Монгол Дагуурын дархан цаазат газар багтсан Монгол, ОХУ, БНХАУ-ын зэрэгцсэн тусгай хамгаалалттай газар, Увс нуурын ай савын дархан цаазат газар багтаж буй Монгол, ОХУ-ын зэрэгцсэн тусгай хамгаалалттай газрыг байгуулж, шинээр зэрэгцсэн тусгай хамгаалалттай 2 газрыг бий болгохоор урьдчилсан байдлаар хэлэлцээр хийв. <p><u>Цаашид анхаарах асуудлууд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 3 дах шинэ үе шат эхэлж буйтай холбоотойгоор хөтөлбөрийн шинэчилсэн нэмэлт өөрчлөлт, ажлын төлөвлөгөөг батлуулах 2. Хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, жил бүр улсын төсөвт суулгаж хэвших, 3. Яамны холбогдох нэгжийн үйл ажиллагааг тогтвортой, орон тооны болгох, хууль эрх зүйн орчныг шинэчлэн боловсронгуй болгоход төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх. 				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 80%	Зорилтын тоо 3	Зорилт 1 80%	Зорилт 2 90 %	Зорилт 3 70%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %				

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР